

Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газрын даргын 2023 оны 09 дугаар сарын 18-ны өдрийн 44 дугаар тушаалын 33 дугаар хавсралт



АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН МАЯГТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулах үндэслэл

Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

Байгууллагын нэр:

Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газар

Нэгжийн нэр:

Инженерийн байгууламж ашиглалт үйлчилгээний алба

Албан тушаалын нэр:

Сүлжээний инженер

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Гүйцэтгэх албан тушаалтан ТҮ-7

Ажлын цаг:

Ажлын 8 цаг

Ажлын байрны албан ёсны байршил:

Хангарди ордон, Ц.Жигжиджавын гудамж - 9, 1 дүгээр хороо, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл:

Шаардлагатай үед амралт, баяр ёслолын өдрүүдэд ажиллах

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Байгууллагын өдөр тутмын үйг ажиллагаанд ашиглагддаг техник хэрэгслийг ажлын байнгын бэлэн байдалд байлгах, сүлжээний хэвийн ажиллагааг хангах, аливаа доголдол гарсан тохиолдолд гэмтлийг тогтоон шуурхай засварлах, техник тоног төхөөрөмжийн аюулгүй байдал, бүрэн бүтэн байдлыг хариуцах

Албан тушаалын зорилт:

1. Байгууллагын үйл ажиллагааны хэвийн байдлыг хангахад чиглэгдсэн техник тоног төхөөрөмжийн хэвийн аюулгүй үйл ажиллагааг ханган ажиллах

2. Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх, техник хангамжийн ажлын үр дүнг дээшлүүлэх, байгууллагын эрхэм зорилгыг хэрэгжүүлж ажиллах
3. Холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажиллах
4. Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль болон холбогдох стандарт, дүрэм журмыг мөрдөж ажиллах

| Зорилт | Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг | Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | Хариуцлага оролцооны хэлбэр Туслах-Т Хариуцан гүйцэтгэх-Г Хянах-Х Шийдвэрлэх-Ш |
|---------------------------|---|--|--|
| 1 дүгээр зорилтын хүрээнд | <p>1.1 Байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад чиглэгдсэн техник тоног төхөөрөмжийн судалгаан дээр ажиллах.</p> <p>1.2 Өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглагддаг техник тоног төхөөрөмжийн хэвийн найдвартай ажиллагааг хангах, сүлжээний тасалдалгүй байдлыг хариуцах</p> <p>1.3 Байгууллагын албан хаагчдын дотоод шилжилт хөдөлгөөн болон шинэ албан хаагчдын хариуцсан компьютер, бусад техник хэрэгслийг хүлээлцүүлэх, хүлээлцүүлсэн, төхөөрөмжийн хэвийн ажиллагааг шалгах.</p> <p>1.4 Техник хангамжийн засвар үйлчилгээ үзүүлэх, зөвлөгөө өгөх, шаардлагатай арга зүйгээр хангаж ажиллах.</p> <p>1.5 Сүлжээнд холбогдсон төхөөрөмжийн IP хаягийн удирдлага, хуваарилалт хийх</p> <p>1.6 Камерын хяналтын тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагаанд хяналт тавьж ажиллах</p> <p>1.7 Хурлын заалны тоног төхөөрөмжийн тохиргоо хийх</p> | Байгууллагын техник тоног төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагаа хангагдсан байна | Г |
| 2 дугаар зорилтын хүрээнд | <p>2.1 Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь өндөр гүйцэтгэлтэй биелүүлэх</p> <p>2.2 Ажлын төлөвлөгөө жил, улирлаар</p> <p>2.3 Сүлжээний төхөөрөмжийн тохиргоо, ашиглалттай холбоотой өөрчлөлтийн удирдлагыг хариуцах</p> <p>2.4 Шаардлагатай ажил үүргүүдийг</p> | Байгууллагын үйл ажиллагаа жигд тасралтгүй явагдсан байна. | Г |

| | | | |
|---------------------------|---|---|---|
| | гүйцэтгэж, мэдээллийн систем болон байгууллагын эрхэм зорилгыг хэрэгжүүлэх | | |
| 3 дугаар зорилтын хүрээнд | 3.1.Монгол Улсын хууль тогтоомжууд болон байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, холбогдох журмуудыг биелүүлж ажиллах 3.2.Монгол улсад хэрэгжиж буй холбогдох стандартын хэрэгжилтийг хангаж ажиллах 3.3.ХАБЭА-н ерөнхий шаардлагыг мөрдөж ажиллах | Хууль тогтоомж, дүрэм журмыг хэрэгжүүлсэн байна. | Г |
| 4 дүгээр зорилтын хүрээнд | 4.1 Архив, албан хэрэг хөтлөлтийн стандарт, зөвлөмжийг мөрдөж ажиллах | Архив, албан хэрэг хөтлөлтийн стандарт, зөвлөмжийг мөрдөж ажиллах | Г |

III. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА



| | |
|-------------------------|---|
| Боловсрол | Бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй |
| Мэргэжил | Шаардахгүй |
| Мэргэшил | Шаардлагатай бол тухайн албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэргэшлийн чиглэлээр мэргэшсэн байх. |
| Туршлага | Программ хангамж, сүлжээний чиглэлээр 2-оос доошгүй жил ажилласан байх |
| Ур чадвар | Компьютерын болон тусгай программууд дээр ажиллах, сүлжээний мэдлэг чадвартай, өөрийгөө сорьж хөгжүүлэх шинийг олж мэдэх эрмэлзэлтэй, мэдлэгээ байнга хөгжүүлэх тасралтгүй суралцах, багаар ажиллах чадвартай, программ хангамж хөгжүүлэлттэй холбоотой бусад чадваруудыг эзэмшсэн байх |
| Тусгай шаардлага | Төрийн албаны ёс зүйн хэм хэмжээг чанд сахих, байгууллагын болон хувь хүний нууцыг хадгалах, ажлын ачаалал даах чадвартай, ажил, ажлын цагаа зөв хуваарилах чадвартай байх |

IV. АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

| | |
|---|---|
| Албан тушаалыг шууд харъяалан удирдах албан тушаалын нэр: Газрын дарга Хэлтэс, албадын дарга нар Дотоод хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан ажилтан | |
| Албан тушаалын шууд харъяалан удирдах албан тушаал: Цэвэрлэгээ, үйлчилгээ, инженер техникийн ажидтнууд | |
| Албан тушаалын байгууллага дотор харилцах субъект: Газрын дарга | Бусад харилцах субъект: 1. Мэргэжлийн байгууллага болон Нийслэлийн Засаг захиргааны |

| | |
|---|--|
| <p>Хэлтсийн дарга Албадын дарга нар Инженерүүд Ерөнхий менежерүүд Байр хариуцсан менежерүүд Бусад ажилтнууд</p> | <p>байранд байрлах байгууллагууд түүний албан хаагчид 2. Нийслэлийн Цахим хөгжил, мэдээллийн технологийн газар 3. Гэрээгээр тоног төхөөрөмж, Программ хангамж нийлүүлдэг байгууллагууд</p> |
|---|--|

V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

| | |
|--|--|
| <p>Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан ажлын хэсгийн ахлагч:</p> | <p>Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:</p> |
| <p>Албан тушаалын нэр: ЗАХИРГАА, ТӨЛӨВЛӨЛТИЙН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР</p> <p> Б.ЗОЛБАЯР (гарын үсэг) (овог, нэр)</p> <p>2023 оны 09 дугаар сарын 13-ны өдөр</p> | <p>Албан тушаалын нэр: НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ</p> <p> Л.ДЭЛГЭР (гарын үсэг, тамга) (овог, нэр)</p> <p>2023 оны 09 дугаар сарын 13-ны өдөр</p> |